



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/484

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Баянзүрх дүүргийн 10, 12, 13, 25, 26 дугаар хорооны хүн амд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцаж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх багцад заасан зарим тусламж, үйлчилгээг үзүүлж, даатгалын сангаас санхүүжилт авахтай холбогдуулан Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн магадлан итгэмжлэлийг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцсугай.
3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081917

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
20 дүгээр сарын 28 - ны өдрийн
А/1484 дугаар тушаалын хавсралт

**Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн
байгууллагуудын нэрс**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлэг	202/2019	2 жил	2019-10-01	2021-10-01
2.	"Аюурвэйд-Энх" ХХК-ний "Су Джок" эмнэлэг	203/2019	2 жил	2019-09-25	2021-09-25
3.	Буянт оношилгоо ХХК-ний эмнэлэг	204/2019	2 жил	2019-09-20	2021-09-20
4.	"Гарьд манлай" ХХК-ний эмнэлэг	205/2019	2 жил	2019-09-13	2021-09-13
5.	Баянзүрх дүүргийн "Миний зөвлөгч" өрхийн эрүүл мэндийн төв	206/2019	2 жил	2019-10-27	2021-10-27
6.	Сүхбаатар дүүргийн "Энхийн санаа" өрхийн эрүүл мэндийн төв	207/2019	2 жил	2019-08-28	2021-08-28
7.	Сонгинохайрхан дүүргийн "Ариун-Энэрэл" өрхийн эрүүл мэндийн төв	208/2019	2 жил	2019-10-22	2021-10-22
8.	Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвийн дэргэдэх сувиллын газар	209/2019	2 жил	2019-10-27	2021-10-27
9.	Грандмед ХХК-ний Баатар ван сувилал	210/2019	2 жил	2019-08-31	2021-08-31
10.	Дархан-Уул аймгийн "МЭДС ТОВ" өрхийн эрүүл мэндийн төв	211/2019	2 жил	2019-10-27	2021-10-27
11.	Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын сум дундын эмнэлэг	212/2019	1 жил	2019-09-01	2020-09-01
12.	Хөвсгөл аймгийн Арбулаг сумын эрүүл мэндийн төв	213/2019	1 жил	2019-12-21	2020-12-21
13.	Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын эрүүл мэндийн төв	214/2019	2 жил	2019-09-01	2021-09-01

14.	Хөвсгөл аймгийн “Хөвсгөл Оюу-Ундраа” ХХК-ний Оюу-Ундраа эмнэлэг	215/2019	2 жил	2019-12-21	2021-12-21
15.	Төв аймгийн “Мон аврагас” ХХК-ний “Эх булаг” сувилал	216/2019	1 жил	2019-10-22	2020-10-22